



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААН,
ОЮУНЫ ӨМЧ**

2019

Улаанбаатар хот
2020 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ..... | 4 |
| БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 5 |
| 1.0. 2019/2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ ҮР ДҮН | 5 |
| 1.1. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 6 |
| 1.2. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ | 7 |
| 1.3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 8 |
| 1.3.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага | 9 |
| 1.3.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд | 10 |
| 2.3.3. Хамран сургалт..... | 11 |
| 1.3.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт | 13 |
| 1.3.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид | 14 |
| 1.4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 16 |
| 1.4.1. Ерөнхий боловсролын сургууль | 17 |
| 1.4.2. Суралцагчид | 17 |
| 1.4.3. Нэгдүгээр ангид элсэгчид..... | 20 |
| 1.4.4. Хамран сургалт..... | 21 |
| 1.4.5. Сургуульд хамрагдаагүй хүүхэд..... | 22 |
| 1.4.6. Бүлэг дүүргэлт | 23 |
| 1.4.7. Төгсөгчид | 24 |
| 1.4.8. Элсэлтийн ерөнхий шалгалт | 25 |
| 1.4.9. Ажиллагчид | 25 |
| 1.5. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 28 |
| 1.5.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага | 29 |
| 1.5.2. Суралцагчид | 29 |
| 1.5.3. Шинээр элсэгчид | 32 |
| 1.5.4. Төгсөгчид | 33 |
| 1.5.5. Ажиллагчид | 33 |
| 1.6. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 34 |
| 1.6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага..... | 35 |
| 1.6.2. Суралцагчид | 36 |
| 1.6.3. Шинээр элсэгчид | 40 |
| 1.6.4. Төгсөгчид | 40 |
| 1.6.5. Ажиллагчид | 43 |
| 1.6.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид | 45 |
| 1.7. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ..... | 46 |

| | |
|---|----|
| 1.8. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ | 47 |
| 1.8.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт | 47 |
| 1.8.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт | 48 |
| 1.9. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ | 51 |
| БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ | 54 |
| ХАВСРАЛТ | 55 |
| 1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ | 55 |
| 1.1.Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт | 55 |
| 1.2.Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт | 56 |
| 2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР | 57 |
| 3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ | 57 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|--------|---|
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| МУ-ын | Монгол Улсын |
| ЗГ | Засгийн газар |
| ЮНЕСКО | НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| ХАОСТ | Хүн ам, орон сууцны тооллого |
| АХС | Ажиллах хүчний судалгаа |
| ӨНЭЭС | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа |
| НҮТС | Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа |
| СӨБ | Сургуулийн өмнөх боловсрол |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЖТБИ | Жендэрийн тэнцвэрт байдлын индекс |
| БНХАУ | Бүгд найрамдах Хятад ард улс |
| ОХУ | Оросын холбооны улс |
| БНКУ | Бүгд найрамдах Казакстан улс |
| БНТУ | Бүгд найрамдах Турк улс |
| БНАЛАУ | Бүгд найрамдах ардчилсан Лаос ард улс |
| БНСУ | Бүгд найрамдах Солонгос улс |
| ХБНГУ | Холбооны бүгд найрамдах Герман улс |

БҮЛЭГ I. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.0. 2019/2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ ҮР ДҮН

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАГА



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАГА



ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАГА, СУРАЛЦАГЧИД, ТӨГСӨГЧИД



ДЭЭД БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛАГА, СУРАЛЦАГЧИД, ТӨГСӨГЧИД




1.1. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлт | 2018 | 2019 | Өсөлт, бууралт, % |
|--|---------|---------|----------------------|
| Цэцэрлэгийн тоо | 1 435 | 1 439 | 0.3 ↑ |
| Ерөнхий боловсролын сургууль, тоогоор | 803 | 820 | 2.1 ↑ |
| Хот | 245 | 258 | 5.3 ↑ |
| Хөдөө | 558 | 562 | 0.7 ↑ |
| Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, тоогоор | 86 | 80 | 7.0 ↓ |
| Их, дээд сургууль, коллеж, тоогоор | 94 | 95 | 1.1 ↑ |
| Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчид | 261 354 | 263 333 | 0.8 ↑ |
| Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид | 593 150 | 640 449 | 8.0 ↑ |
| Бага анги | 327 019 | 342 634 | 4.8 ↑ |
| Дунд анги | 184 017 | 200 806 | 9.1 ↑ |
| Ахлах анги | 82 114 | 97 009 | 18.1 ↑ |
| Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчид | 37 039 | 37 806 | 2.1 ↑ |
| Их, дээд сургууль, коллежид суралцагчид | 157 625 | 148 446 | 5.8 ↓ |
| Бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багш, мянган хүн | 47.4 | 49.9 | 5.3 ↑ |
| СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин, % | 79.3 | 81.5 | 2.2 пункт ↑ |
| Цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхэд | 30.6 | 32.6 | 6.5 ↑ |
| Бага боловсролын бүлэг дүүргэлт | 31 | 32 | 3.2 ↑ |
| Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин, % | 95.5 | 95.7 | 0.2 пункт ↑ |
| Дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин, % | 92.6 | 93.3 | 0.7 пункт ↑ |
| Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин, % | 94.5 | 94.9 | 0.4 пункт ↑ |
| ЕБС-ийн нэгдүгээр ангид шинээр элсэгчид | 72 247 | 76 892 | 6.4 ↑ |
| ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа | 19.5 | 20.0 | 2.6 ↑ |
| Техникийн болон мэргэжлийн боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс | 65 | 70 | 7.7 ↑ |
| Техникийн болон мэргэжлийн боловсролд шинээр элсэгчид | 23 512 | 22 648 | 3.7 ↓ |
| Их, дээд сургууль, коллежид суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс | 146 | 157 | 7.5 ↑ |
| Их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчид | 44 094 | 17 566 | 60.2 ↓ |
| Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын салбарын зардлын эзлэх хувь | 15.0 | 15.3 | 0.3 пункт ↑ |
| ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь | 4.3 | 4.7 | 0.4 пункт ↑ |
| Шинжлэх ухааны байгууллагын тоо | 59 | 62 | 5.1 ↑ |
| Шинжлэх ухааны байгууллагын эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид | 3 246 | 3 352 | 3.3 ↑ |
| Хүчинтэй байгаа патент, тоогоор | 4 739 | 4 417 | 6.8 ↓ |
| Хүчинтэй байгаа ашигтай загвар, тоогоор | 916 | 995 | 8.6 ↑ |
| Хүчинтэй байгаа барааны тэмдэг, тоогоор | 45 696 | 47 983 | 5.0 ↑ |

1.2. ХҮН АМЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

2020 оны ҮСХ-ны “Хүн ам, орон сууцны тооллого”-ын үр дүнгээс харахад, 10, түүнээс дээш насны нийт эмэгтэйчүүдийн 31.1 хувь нь дээд боловсролтой байгаа бол нийт эрэгтэйчүүдийн 30.8 хувь нь бүрэн дунд боловсролтой байна.


Зураг 2. 10, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, хувиар, 2020 он



Бичиг үсгийн мэдлэг нь хүний эрхийн хамгийн чухал хэсэг бөгөөд чанартай суурь боловсрол нь бичиг үсгийн мэдлэгтэй хүүхдийг цаашдын амьдрал, сургалт боловсролд хөтөлдөг бол бичиг үсгийн мэдлэгтэй, боловсролтой эцэг, эхчүүд хүүхдээ эрүүл чийрэг өсгөж, сургуульд суралцуулах боломжийг илүү бүрдүүлдэг. Түүнчлэн нэгдмэл, боловсролтой ард түмэн хөгжлийн тулгамдсан асуудлууд, сорилтыг давах, шийдвэрлэх хүчирхэг хүч болдог¹.

Монгол Улсын 15, түүнээс дээш хүн амын бичиг үсгийн мэдлэг 1921 онд 2.1 хувь байсан бол 1944 онд 27.3 хувь, 1956 онд 70.5 хувь болж огцом өсөж, 1979 онд 92.7 хувь, 1989 онд 96.5 хувь, 2000 онд 97.8 хувь, 2010 онд 98.3 хувь, 2020 онд 98.7 хувь болж түс түс өсжээ.

Зураг 1. Хүн амын бичиг үсгийн мэдлэг, хувиар



¹ “International Literacy Statistics: Review of Concepts, Methodology and Current Data”, UNESCO, 2008

1.3. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ




1.3.1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага

Монгол Улсын хэмжээнд 2010/2011 оны хичээлийн жилд нийт 839 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бол тогтмол өссөөр 2019/2020 оны хичээлийн жилд 1439 болж, 600 (71.5%)-гаар нэмэгдсэн байна.


2019/2020 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй нийт цэцэрлэгийн 910 (63.2%) нь төрийн өмчийн (Улаанбаатар төмөр замын харьяа 27 цэцэрлэг), 529 (36.8%) нь төрийн бус өмчийн цэцэрлэг байна. Цэцэрлэгийн тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 4 (0.3%) (төрийн өмчийнх 21 (2.4%)-ээр нэмэгдэж, хувийнх 17 (3.1 %))-гоор нэмэгдсэн байна.

Зураг 4. Цэцэрлэгийн тоо, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он



Цэцэрлэгийн тоог сүүлийн 10 жилээр авч үзвэл, Улаанбаатар хотын цэцэрлэгийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 266 байсан бол тасралтгүй өссөөр 2019/2020 оны хичээлийн жилд 2.6 дахин өссөн байна.

Зураг 5. Цэцэрлэгийн тоо, бүсээр, 2010-2019 он




1.3.2. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд

СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 157.2 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 263.3 мянга болж, 106.2 мянга (67.5%)-аар өссөн байна.

СӨБ-ын байгууллагад 2019/2020 оны хичээлийн жилд хамрагдсан хүүхдүүдийн 20.7 мянга (7.9 %) нь хувилбарт сургалтад хамрагдаж байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилээс 14.4 мянга (41.0 %)-аар буурсан байна.


2019/2020 оны хичээлийн жилд хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдүүдийн 3.2 мянга нь ээлжийн бүлэгт, 15.0 мянга нь нүүдлийн бүлэгт, 2.5 мянга нь явуулын багшийн сургалтаар дамжуулан сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 6. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, сургалтын төрлөөр, 2010-2019 он




СӨБ-ын байгууллагад 2019/2020 оны хичээлийн жилд хамрагдсан хүүхдүүдийн 225.0 мянга (85.4 %) нь төрийн өмчийн цэцэрлэгт, 38.4 мянга (14.6 %) хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.

Зураг 7. СӨБ-ын байгууллагад хамрагдсан хүүхэд, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он



Дараах зургаас харахад сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй нийт хүүхдийн тоо 2019/2020 оны хичээлийн жилд 1076 болж, 2010/2011 оны хичээлийн жилээс 144-өөр, өмнөх хичээлийн жилээс 11 хүүхдээр тус тус буурсан байна.


Зураг 8. СӨБ-д хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, 2010-2019 он



2.3.3. Хамран сургалт


2019/2020 оны хичээлийн жилд 2-5 насны нийт хүүхдийн 81.5 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилээс 6.2 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 9. Хамран сургалтын цэвэр жин, хувиар, 2010-2019 он




Монгол Улсын 2-5 насны хүн амд СӨБ-д хамрагдсан хүүхдийн эзлэх хувийг аймгаар авч үзвэл, Баян-Өлгий аймагт хамгийн бага (64.9%), Говь-Сүмбэр аймагт хамгийн өндөр (94.1%) байна.

Зураг 10. Хамран сургалтын цэвэр жин, хувиар, аймаг, нийслэлээр, 2019/2020 оны хичээлийн жилд



Хамран сургалтын цэвэр жин Улаанбаатар хотод 78.5 хувь байгаа бөгөөд дүүргээр авч үзвэл, Сонгинохайрхан дүүрэгт хамгийн бага (69.5 %), Баянгол дүүрэгт хамгийн өндөр (90.5 %) байна.


Зураг 11. Хамран сургалтын цэвэр жин, хувиар, нийслэл, дүүргээр, 2019/2020 оны хичээлийн жилд



1.3.4. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт


2019/2020 оны хичээлийн жилд улсын дүнгээр цэцэрлэгийн нэг бүлэг дунджаар 33 хүүхэдтэй байна. Харин энэ үзүүлэлтийг бүлгээр харуулбал, хамгийн олон хүүхэдтэй нь бэлтгэл бүлэг (36), ахлах бүлэг (35), хамгийн цөөхөн хүүхэдтэй нь холимог бүлэг (22) байна.

Зураг 12. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, бүлгээр, 2019/2020 оны хичээлийн жилд



2019/2020 оны хичээлийн жилд Улаанбаатар хотын цэцэрлэгийн нэг бүлэг дунджаар 34 хүүхэдтэй байна. Харин энэ үзүүлэлтийг дүүргээр харуулбал, нэг бүлэгт ногдох хүүхдийн тоогоор Налайх дүүрэг (36) хамгийн өндөр, хамгийн цөөхөн хүүхэдтэй нь Багахангай дүүрэг (22) байна.

Зураг 13. Улаанбаатар хотын цэцэрлэгийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, дүүргээр, 2019/2020 оны хичээлийн жилд



1.3.5. СӨБ-ын байгууллагын ажиллагчид


2019/2020 оны хичээлийн жилд СӨБ-ын байгууллагын нийт үндсэн багш 8.1 мянга болж, 2010/2011 оны хичээлийн жилээс 3.4 мянга (73.5 %)-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. СӨБ-ын байгууллагын нийт ажиллагчид, 2010-2019 он

| Үзүүлэлт | 2010/2011 | 2011/2012 | 2012/2013 | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 |
|------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Бүгд | 16 659 | 17 626 | 19 495 | 21 019 | 21 962 | 24 179 | 25 639 | 27 172 | 27 214 | 28 070 |
| Эмэгтэй | 13 889 | 14 715 | 16 347 | 17 716 | 18 641 | 20 484 | 21 787 | 23 139 | 23 112 | 23 869 |
| Эрхлэгч | 816 | 851 | 923 | 1 015 | 1 073 | 1 204 | 1 261 | 1 307 | 1 359 | 1 352 |
| Эмэгтэй | 805 | 839 | 912 | 993 | 1 051 | 1 173 | 1 234 | 1 275 | 1 311 | 1 305 |
| Үндсэн багш | 4 651 | 4 907 | 5 332 | 5 895 | 6 158 | 6 833 | 7 302 | 7 745 | 7 843 | 8 068 |
| Эмэгтэй | 4 569 | 4 813 | 5 238 | 5 773 | 6 046 | 6 686 | 7 142 | 7 542 | 7 609 | 7 809 |
| Туслах багш | 4 082 | 4 326 | 4 769 | 5 249 | 5 589 | 6 133 | 6 508 | 6 970 | 6 673 | 6 870 |
| Эмэгтэй | 4 079 | 4 321 | 4 767 | 5 240 | 5 585 | 6 130 | 6 503 | 6 963 | 6 667 | 6 861 |
| Арга зүйч | 325 | 373 | 393 | 419 | 446 | 510 | 547 | 606 | 665 | 715 |
| Эмэгтэй | 323 | 371 | 390 | 416 | 442 | 505 | 543 | 600 | 660 | 704 |
| Бусад ажиллагчид | 6 785 | 7 169 | 8 078 | 8 441 | 8 696 | 9 499 | 10 021 | 10 544 | 10 674 | 11 065 |
| Эмэгтэй | 4 113 | 4 371 | 5 040 | 5 294 | 5 517 | 5 990 | 6 365 | 6 759 | 6 865 | 7 190 |


Улсын хэмжээнд 2019/2020 оны хичээлийн жилд нэг багшид 33 хүүхэд ногдож байна. Харин нэг багшид ногдох хүүхдийн тоогоор Баян-Өлгий (28.0), Сэлэнгэ аймаг (28.0) хамгийн бага байгаа бол Өвөрхангай аймагт хамгийн өндөр (48.3) байна.

Зураг 14. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, аймаг, нийслэлээр, 2019/2020 оны хичээлийн жилд



Энэ үзүүлэлтийг нийслэл, дүүргээр харвал, Налайх дүүрэг (42.3) хамгийн өндөр, Багахангай дүүрэг (22.5) хамгийн бага байна.

Зураг 15. Нэг багшид ногдох хүүхдийн тоо, нийслэл, дүүргээр, 2019/2020 оны хичээлийн жилд




1.4. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ



1.4.1. Ерөнхий боловсролын сургууль


2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 820 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагийн 78 (9.5 %) нь бага сургууль, 113 (13.8 %) нь дунд сургууль, 584 (71.2 %) нь ахлах сургууль, 45 (5.5 %) нь цогцолбор сургууль байна. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын 80.7 хувь нь төрийн өмчийн, 19.3 хувь нь хувийн өмчийн сургууль байна.

Зураг 16. Ерөнхий боловсролын сургууль, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он



2019/2020 оны хичээлийн жилд нийт сургуулийн 562 (68.5 %) нь хөдөөд, 258 нь (31.5 %) хотод сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна.


Зураг 17. Ерөнхий боловсролын сургуулийн тоо, хот, хөдөөгөөр, 2010-2019 он



1.4.2. Суралцагчид


2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд нийт 646.8 мянган (өдрөөр 640.4 мянга, орой, эчнээгээр 211, дүйцсэн хөтөлбөрөөр 6.2 мянга) хүүхэд суралцсан байна. Нийт суралцагчид 2010/2011 оны хичээлийн жилээс 119.7 мянгаар өссөн байна.

Зураг 18. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчид, сургалтын хэлбэрээр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он




2019/2020 оны хичээлийн жилд өдрөөр нийт 640.4 мянган хүүхэд суралцаж байгаагийн 92.7 хувь нь төрийн өмчийн сургуульд, 7.3 хувь нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

Зураг 19. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он




2019/2020 оны хичээлийн жилд ахлах ангид 97.0 мянган хүүхэд суралцаж байгаагийн 45.3 хувь нь хөвгүүд, 54.7 хувь нь охидууд байна.

Зураг 20. Ерөнхий боловсролын сургуулийн өдрөөр суралцагчид, ангиар, 2019/2020 оны хичээлийн жилд



2019/2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд 6.1 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилээс 12.2 мянга (66.9 %) -аар буурсан байна.


Зураг 21. ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2010-2019 он



Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр 2019/2020 оны хичээлийн жилд 532 болж, 2010/2011 оны хичээлийн жилээс 21-ээр нэмэгджээ.


2019/2020 оны хичээлийн жилд дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 38.7 мянган хүүхдээс 92.4 % (35.8 мянга) нь дотуур байранд амьдарч байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилээс 2.4 пунктээр нэмэгдсэн байна.

Зураг 22. Хүсэлт гаргасан нийт хүүхэд болон дотуур байранд амьдарч буй хүүхдийн эзлэх хувь, 2010-2019 он



2019/2020 оны хичээлийн жилд ЕБС-д малчдын 119.1 мянган хүүхэд суралцаж байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад 0.5 мянга (0.4 %) -аар буурсан байна. Нийт малчин өрхийн хүүхдүүдийн 27.1 мянга (22.8 %) нь дотуур байранд амьдарч байна.

Зураг 23. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа малчин өрхийн нийт болон дотуур байранд амьдарч буй хүүхэд, мянган хүүхэд, 2010-2019 он



1.4.3. Нэгдүгээр ангид элсэгчид

2019/2020 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид шинээр нийт 76.9 мянган хүүхэд элссэний 80.2 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байна.

Зураг 24. Нэгдүгээр ангид шинээр элсэгчдийн дотор сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь, 2010-2019 он




1.4.4. Хамран сургалт

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж тооцсон бөгөөд бага боловсролын (1-5-р анги) хамран сургалтын цэвэр жин 2019/2020 оны хичээлийн жилд 95.7 хувь болж, 2010/2011 оны хичээлийн жилээс 2.5 пунктээр буурч, өмнөх хичээлийн жилээс 0.2 пунктээр өссөн байна.


Дунд ангийн (6-9-р анги) хамран сургалтын цэвэр жин 2019/2020 оны хичээлийн жилд 93.3 хувь болж, 2010/2011 оны хичээлийн жилээс 21.6 пунктээр өссөн байна.

Зураг 25. Хамран сургалтын цэвэр жин, хувиар, 2010-2019 он



Улсын хэмжээнд бага боловсролын (1-5 анги) хамран сургалтын бохир жин (нас харгалзахгүйгээр тооцсон) 2019/2020 оны хичээлийн жилд 96.8 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.2 пунктээр нэмэгдэж, дунд боловсролынх 97.5 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 0.5 пунктээр буурсан байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жинг аймгаар авч үзвэл, хамгийн өндөр нь Дархан-Уул аймагт (102.0 %), хамгийн бага нь Өвөрхангай аймагт (89.1 %) байна.


Зураг 26. Бага боловсролын хамран сургалтын бохир жин, хувиар, аймгаар, 2019/2020 оны хичээлийн жилд



1.4.5. Сургуульд хамрагдаагүй хүүхэд

2019/2020 оны хичээлийн жилд бага боловсролд хамрагдвал зохих 6-10 настай нийт хүүхдүүдийн 4.4 хувь буюу 15.1 мянган хүүхэд, дунд ангид хамрагдвал зохих 11-14 насны нийт хүүхдүүдийн 7.3 хувь буюу 13.8 мянган хүүхэд сургуульд хамрагдаагүй байна.


Зураг 27. Сургуульд хамрагдаагүй хүүхэд, ангиар, 2018-2019 он



1.4.6. Бүлэг дүүргэлт


2019/2020 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-ийн нэг бүлэгт 29 хүүхэд, бага ангийн нэг бүлэгт 32 хүүхэд суралцаж байна. Бага ангийн бүлэг дүүргэлтийг өмчийн хэлбэрээр авч үзэхэд, төрийн өмчийн сургуулийн нэг бүлэгт 33 хүүхэд, хувийн өмчийн сургуулийн нэг бүлэгт 21 хүүхэд суралцаж байна.

Зураг 28. ЕБС-ийн бүлэг дүүргэлт, хүүхдээр, 2010-2019 он




ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлтийг аймаг, нийслэлээр авч үзвэл, хамгийн их нь Улаанбаатар хотод (36), Орхон аймагт (34), хамгийн бага нь Говь-Алтай аймагт (23) байна.

Зураг 29. ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлт, хүүхдээр, аймаг, нийслэлээр, 2019/2020 оны хичээлийн жилд



Мөн энэ үзүүлэлтийг дүүргээр авч үзвэл, Сонгинохайрхан дүүрэгт (39) хамгийн өндөр, Багахангай дүүрэгт (23) хамгийн бага байна.


Зураг 30. ЕБС-ийн бага боловсролын бүлэг дүүргэлт, хүүхдээр, дүүргээр, 2019/2020 оны хичээлийн жилд



1.4.7. Төгсөгчид

2018/2019 оны хичээлийн жилд ЕБС-ийг нийт 58.4² мянган хүүхэд (9-р ангийг 41.9 мянга, 12-р ангийг 16.5³ мянга) өдрөөр суралцан төгссөн нь 2010/2011 оны хичээлийн жилээс 26.7 мянгаар буурсан байна.

Зураг 31. ЕБС-ийг нийт өдрөөр суралцан төгсөгчид, ангиар, 2010-2018 он




² ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлсэн Монгол Улсын Их Хурлын 2006 оны 89-р тогтоолын дагуу 12 дугаар ангийг төгсөгчид.

³ Анхны 12 жил суралцан төгсөгчид.

1.4.8. Элсэлтийн ерөнхий шалгалт

Их, дээд сургуульд 2019 онд элсэгчдийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүн буюу хэмжээст оноо (хэмжээст оноо гэдэг нь тухайн хичээлийн нийт гүйцэтгэлийг шалгалтад орсон шалгуулагчдын гүйцэтгэлтэй харьцуулан хэмжээсжүүлсэн оноо)-г хүйсээр авч үзвэл, охид математик, монгол хэл, нийгмийн ухаан, физикийн хичээлүүд дээр хөвгүүдээс өндөр оноо авсан байна.

Зураг 32. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (хэмжээст оноо), хүйсээр, 2019 он



1.4.9. Ажиллагчид

Ерөнхий боловсролын сургуулийн ажиллагчдын тоо 2010/2011 оны хичээлийн жилд 44.1 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 51.6 мянга болж, 7.4 мянга (16.8 %)-аар нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Ерөнхий боловсролын сургуулийн нийт ажиллагчид болон үндсэн багш, 2011-2019 он

| Үзүүлэлт | 2010/2011 | 2011/2012 | 2012/2013 | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 |
|-------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Ажиллагчид | 44 143 | 44 618 | 45 363 | 45 367 | 45 882 | 46 791 | 47 168 | 47 991 | 49 441 | 51 550 |
| Үндсэн багш | 26 358 | 26 492 | 26 863 | 27 205 | 27 449 | 28 490 | 28 889 | 29 242 | 30 411 | 32 085 |
| Бага ангийн | 9 059 | 8 916 | 8 895 | 8 795 | 8 901 | 9 877 | 9 976 | 10 238 | 10 736 | 11 030 |
| Дунд ангийн | 11 061 | 11 217 | 10 877 | 11 184 | 11 233 | 11 454 | 11 708 | 11 960 | 12 670 | 13 703 |
| Ахлах ангийн | 6 238 | 6 359 | 7 091 | 7 226 | 7 315 | 7 159 | 7 205 | 7 044 | 7 005 | 7 352 |

2019/2020 оны хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын сургуульд 32.1 мянган үндсэн багш ажиллаж байгаагийн 26.1 мянга (81.5 %) нь эмэгтэй багш байна.

Хүснэгт 4. Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн багш, 2010-2019 он


| Үзүүлэлт | 2010/2011 | 2011/2012 | 2012/2013 | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 |
|----------------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Үндсэн багш | 26 358 | 26 492 | 26 863 | 27 205 | 27 449 | 28 490 | 28 889 | 29 242 | 30 411 | 32 085 |
| Эмэгтэй | 21 614 | 21 717 | 21 936 | 22 051 | 22 285 | 23 120 | 23 479 | 23 876 | 24 879 | 26 149 |
| Боловсролын зэргээр | | | | | | | | | | |
| Доктор | 21 | 21 | 28 | 15 | 23 | 22 | 23 | 23 | 19 | 18 |
| Магистр | 2 819 | 3 013 | 3 144 | 3 220 | 3 670 | 4 085 | 3 983 | 4 034 | 4 347 | 4 767 |
| Бакалавр | 17 118 | 17 647 | 18 354 | 19 065 | 19 441 | 20 142 | 20 949 | 21 185 | 22 301 | 23 722 |
| Диплом | 6 134 | 5 685 | 5 236 | 4 732 | 4 263 | 3 916 | 3 530 | 3 131 | 2 901 | 2 721 |
| Бусад | 266 | 126 | 101 | 173 | 52 | 325 | 404 | 869 | 843 | 857 |
| Насны бүлгээр | | | | | | | | | | |
| 30 нас хүртэл | 8 920 | 8 651 | 8 444 | 8 370 | 8 222 | 8 469 | 8 378 | 8 331 | 8 606 | 8 912 |
| 30-39 нас | 8 728 | 9 067 | 9 422 | 9 686 | 10 011 | 10 277 | 10 406 | 10 526 | 10 741 | 11 361 |
| 40-49 нас | 5 574 | 5 505 | 5 455 | 5 519 | 5 688 | 6 056 | 6 520 | 6 807 | 7 317 | 7 820 |
| 50-59 нас | 2 989 | 3 114 | 3 353 | 3 447 | 3 369 | 3 515 | 3 389 | 3 365 | 3 462 | 3 607 |
| 60, түүнээс дээш | 147 | 155 | 189 | 183 | 159 | 173 | 196 | 213 | 285 | 385 |
| Ажилласан жилээр | | | | | | | | | | |
| 1 жил хүртэл | 1 171 | 1 138 | 1 205 | 934 | 611 | 2 110 | 1 675 | 1 732 | 1 838 | 2 072 |
| 1-5 жил | 6 895 | 6 531 | 6 116 | 6 585 | 8 196 | 8 869 | 9 405 | 9 287 | 9 919 | 8 296 |
| 6-10 жил | 5 703 | 5 918 | 6 256 | 6 554 | 6 974 | 5 740 | 5 892 | 5 866 | 5 752 | 7 705 |
| 11-15 жил | 3 423 | 3 666 | 3 851 | 4 115 | 4 158 | 4 785 | 4 348 | 4 576 | 4 825 | 5 307 |
| 16-20 жил | 2 530 | 2 422 | 2 455 | 2 524 | 2 465 | 2 321 | 2 669 | 2 900 | 3 082 | 3 348 |
| 21-25 жил | 2 823 | 2 636 | 2 584 | 2 312 | 1 979 | 1 396 | 1 420 | 1 446 | 1 562 | 1 733 |
| 26, түүнээс дээш | 3 813 | 4 181 | 4 396 | 4 181 | 3 066 | 3 269 | 3 480 | 3 435 | 3 433 | 3 624 |



2019/2020 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ЕБС-ийн нэг багшид 20.0 хүүхэд ногдож байгаа бол бага ангийн нэг багшид 31.1 хүүхэд ногдож байна.


Харин нэг багшид ногдох хүүхдийн тоог аймгаар авч үзвэл, Баян-Өлгий аймагт хамгийн бага (14.9) байгаа бол Дорноговь аймагт хамгийн өндөр (21.5) байна.

Зураг 33. Сурагч-багшийн тооны харьцаа (нэг багшид ногдох сурагчдын тоо), аймаг, нийслэлээр, 2019/2020 оны хичээлийн жилд



Нэг багшид ногдох суралцагчдын тоог дүүргээр авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд энэхүү үзүүлэлт Сонгинохайрхан дүүрэгт хамгийн өндөр, харин Сүхбаатар дүүрэгт хамгийн бага байна.

Зураг 34. Сурагч-багшийн тооны харьцаа (нэг багшид ногдох сурагчдын тоо), нийслэл, дүүргээр, 2019/2020 оны хичээлийн жилд




1.5. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ



1.5.1. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо 2010/2011 оны хичээлийн жилд 63 байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 80 болж, 17 (27.0 %)-гоор нэмэгдсэн байна.

Зураг 35. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он




2019/2020 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсролын 80 сургууль сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 62.5 хувь нь төрийн өмчийнх, 37.5 хувь нь хувийн өмчийнх байна.

1.5.2. Суралцагчид

Суралцагчдын тоо 2011-2017 онуудад тасралтгүй буурсан бол 2018/2019 оны хичээлийн жилээс бага зэрэг өсөж, 2019/2020 оны хичээлийн жилд 37.8 мянга болсон байна.


Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 25.6 мянга (55.5 %) нь эрэгтэй суралцагчид байсан бол энэ үзүүлэлт 2019/2020 оны хичээлийн жилд 22.3 мянга (58.9 %) болсон байна.

Зураг 36. Нийт суралцагчид, хүйсээр, мянган хүн, 2010-2019 он




Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын тоог аймгаар авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт 37.8 мянган суралцагчдын 19.0 мянга (50.2 %) нь Улаанбаатар хотод, 2.0 мянга (5.4 %) нь Дархан-Уул аймагт, 1.5 мянга (4.0 %) нь Төв аймагт, 15.3 мянга (40.4 %) нь бусад аймагт суралцаж байна.

Зураг 37. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2019/2020 оны хичээлийн жилд



Мэргэжлийн боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдал (ЖТБ⁴)-ын индекс буюу мэргэжлийн боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2019/2020 оны хичээлийн жилд 70 байна.


Зураг 38. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс, 2010-2019 он



⁴ Жендэрийн тэнцвэрт байдлын индекс нь тухайн шатны боловсролыг эзэмшиж буй 100 эрэгтэй тутамд ногдох эмэгтэйн тоог харуулна.


Суралцагчдыг сургалтын төрлөөр нь авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт 37.8 мянган суралцагчдын 30.5 мянга (80.7 %) нь мэргэжлийн боловсролд, 6.4 мянга (16.8 %) нь техникийн боловсролд, 0.9 мянга (2.5 %) нь мэргэжлийн сургалтад суралцаж байна.

Зураг 39. Нийт суралцагчид, мянган хүн, сургалтын төрлөөр, 2014-2019 он




Суралцагчдын тоог салбараар авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 11.1 мянга (29.4 %) нь аж үйлдвэрийн салбарын мэргэжлийг, 7.0 мянга (18.5 %) нь барилгын салбарын мэргэжлийг тус тус сонгон суралцсан байна.

Зураг 40. Нийт суралцагчид, мэргэжлийн чиглэлээр, 2018-2019 он



Тээвэр, уул уурхай, барилгын салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгон суралцаж байгаа бол эмэгтэй оюутнууд эрүүл мэнд, үйлчилгээний салбарт илүүтэй суралцаж байна.


Зураг 41. Нийт суралцагчид, хүйсээр, салбараар, 2019/2020 оны хичээлийн жилд



1.5.3. Шинээр элсэгчид

2019/2020 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагад шинээр элсэгчдийн 8.4 мянга (37.0 %) нь тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид байна.


Зураг 42. Шинээр элсэгчид, тухайн жилд суурь боловсрол эзэмшигчид, 2010-2019 он



1.5.4. Төгсөгчид

2018/2019 оны хичээлийн жилд нийт 21.2 мянган оюутан төгссөн нь 2011/2012 оны хичээлийн жилээс 1.9 мянга (8.3 %)-аар буурсан байна.


Зураг 43. Нийт төгсөгчид, хүйсээр, мянган хүн, 2011-2018 он



1.5.5. Ажиллагчид

Үндсэн багшийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 2.1 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 2.4 мянга болж, 245 (11.4 %)-аар өссөн байна.

Зураг 44. Ажиллагчид болон үндсэн багш, 2010-2019 он



1.6. ДЭЭД БОЛОВСРОЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ




1.6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 113 байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 95 болж, 18 (15.9 %)-аар буурсан байна.


Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоог өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт их, дээд сургууль, коллежийн 97 (85.8 %) нь төрийн бус өмчийн, 16 (14.2 %) нь төрийн өмчийн сургууль эзэлж байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд энэ тоо харгалзан 74 (77.9 %), 21 (22.1 %) байна.

Зураг 45. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он



Дээд боловсролын сургалтын 95 байгууллагын 36.8 хувь нь их сургууль, 52.6 хувь нь дээд сургууль, 7.4 хувь нь коллежийн ангилалд багтаж, 3.2 хувь нь гадаадын салбар сургууль байна.

Зураг 46. Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, ангиллаар, 2010-2019 он




1.6.2. Суралцагчид

Их, дээд сургууль, коллежид суралцагчид 2010/2011 оны хичээлийн жилд 170.1 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 148.4 мянга болж, 12.7 хувиар буурсан байна.


Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 101.5 мянга (59.6 %) нь эмэгтэй суралцагчид байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд энэ үзүүлэлт 90.6 мянга болж, 10.9 мянга (10.7 %)-аар буурсан байна.

Зураг 47. Нийт суралцагчид, хүйсээр, 2010-2019 он




Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг аймгаар авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт 148.4 мянган суралцагчдын 136.4 мянга (91.9 %) нь Улаанбаатар хотод, 4.3 мянга (2.9 %) нь Дархан-Уул аймагт, 7.7 мянга (5.2 %) нь бусад аймагт суралцаж байна.

Зураг 48. Нийт суралцагчид, аймгаар, хүйсээр, 2019/2020 оны хичээлийн жилд




Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 61.4 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцаж байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 55.8 хувь болж, 5.6 пунктээр буурсан байна.

Зураг 49. Нийт суралцагчид, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он



Өнгөрсөн жилүүдийн тоон мэдээллээс харахад, дээд боловсролд суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс буюу дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд ногдож буй эмэгтэй суралцагчдын тоо 2019/2020 оны хичээлийн жилд 157 байгаа нь 2010/2011 оны хичээлийн жилээс нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Зураг 50. Жендэрийн тэнцвэрт байдлын индекс, 2010-2019 он



2010/2011 2011/2012 2012/2013 2013/2014 2014/2015 2015/2016 2016/2017 2017/2018 2018/2019 2019/2020


Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 119.3 мянга (80.4 %) нь бакалавр⁵, 25.8 мянга (17.3 %) нь магистр, 3.4 мянга (2.3 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна. Нийт суралцагчдын тоог 2010/2011 оны хичээлийн жилтэй харьцуулахад бакалаврынх 36.4 мянга (23.4 %)-аар буурсан бол магистрынх 13.7 мянга (2.1 дахин)-аар, докторынх 973 (40.2 %)-аар тус тус өссөн байна.

Хүснэгт 5. Нийт суралцагчид, боловсролын зэргээр, 2010-2019 он

| Үзүүлэлт | 2010/2011 | 2011/2012 | 2012/2013 | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 | 2019/2020 |
|------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| Бүх суралцагчид | 170 126 | 172 798 | 175 591 | 174 075 | 178 295 | 162 626 | 157 138 | 155 248 | 157 625 | 148 446 |
| Үүнээс: Эмэгтэй | 101 455 | 101 557 | 102 427 | 101 783 | 102 520 | 93 674 | 91 526 | 90 094 | 93 552 | 90 573 |
| Дипломын дээд | 4 045 | - | - | - | - | - | - | 124 | 362 | 98 |
| Үүнээс: Эмэгтэй | 3 517 | - | - | - | - | - | - | 21 | 191 | 14 |
| Бакалавр | 151 612 | 154 876 | 155 801 | 152 708 | 155 839 | 140 296 | 133 223 | 130 484 | 130 545 | 119 203 |
| Үүнээс: Эмэгтэй | 88 734 | 90 227 | 90 103 | 88 399 | 88 457 | 79 790 | 76 753 | 74 883 | 76 394 | 71 622 |
| Магистрантур | 12 050 | 14 873 | 16 630 | 18 063 | 19 065 | 19 005 | 20 066 | 20 345 | 22 499 | 25 753 |
| Үүнээс: Эмэгтэй | 7 733 | 9 505 | 10 420 | 11 437 | 12 103 | 11 957 | 12 552 | 12 697 | 14 554 | 17 066 |
| Докторантур | 2 419 | 3 049 | 3 160 | 3 304 | 3 391 | 3 325 | 3 849 | 4 295 | 4 219 | 3 392 |
| Үүнээс: Эмэгтэй | 1 471 | 1 825 | 1 904 | 1 947 | 1 960 | 1 927 | 2 221 | 2 493 | 2 413 | 1 871 |

Нийт суралцагчдыг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд 32.6 мянга (22.0 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлд, 22.9 мянга (15.4 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлд, 20.9 мянга (14.1 %) нь анагаах ухааны чиглэлд, 14.3 мянга (9.6 %) нь инженерийн чиглэлд, 11.2 мянга (7.6 %) нь хууль, эрх зүйн чиглэлд, 46.5 мянга (31.3 %) нь бусад чиглэлд тус тус суралцаж байна.


Зураг 51. Нийт суралцагчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2010-2019 он



Суралцагчдын тоог мэргэжлийн ерөнхий чиглэлээр авч үзвэл, 2019/2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 51.4 мянга (34.6 %) нь, 2010/2011 оны хичээлийн жилд 58.6 мянга (34.5 %) нь нийгмийн ухааны салбарын мэргэжлийг сонгосон байна.


⁵ Бакалаврын зэргийн суралцагчдад дипломын дээд боловсролын зэргийн суралцагчдыг оруулсан.

Зураг 52. Нийт суралцагчид, мянган хүн, мэргэжлийн ерөнхий чиглэлээр




Техник, технологи, үйлчилгээ болон хөдөө аж ахуйн салбаруудыг эрэгтэй оюутан илүүтэй сонгожээ. Тухайлбал, одоогоос 10 жилийн өмнө буюу 2010/2011 оны хичээлийн жилд техник, технологийн салбарт нийт 30.0 мянган оюутан суралцаж байсны 68.3 хувь нь, 2019/2020 оны хичээлийн жилд 24.9 мянган оюутан суралцаж байгаагийн 71.4 хувь нь эрэгтэй байна. Харин анагаах ухааны салбарыг эмэгтэйчүүд илүүтэй сонгон суралцаж байна.

Зураг 53. Нийт суралцагчид, хүйсээр, мэргэжлийн ерөнхий чиглэлээр



Монгол Улсад 2019/2020 оны хичээлийн жилд нийт 959 гадаад оюутан суралцаж байгаагийн 68.6 хувь хөрш зэргэлдээ БНХАУ-ын оюутнууд байна.


Зураг 54. Монгол Улсад суралцаж буй гадаад оюутан, нийт дүнд эзлэх хувиар, улсаар



1.6.3. Шинээр элсэгчид

2019/2020 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид шинээр элсэгчдийн 60.1 хувь нь эмэгтэй байна.


Зураг 55. Шинээр элсэгчид, хүйсээр, 2010-2019 он



1.6.4. Төгсөгчид

Их, дээд сургууль, коллежийг 2010/2011 оны хичээлийн жилд нийт 35.8 мянган оюутан төгссөн бол 2018/2019 оны хичээлийн жилд 23.0 мянга болж, 12.8 мянга (35.7 %) -аар буурсан байна. 2018/2019 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 13.5 мянга (58.7 %) нь эмэгтэй байна.

Зураг 56. Нийт төгсөгчид, хүйсээр, 2010-2018 он



Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд 19.4 мянга (84.0 %) нь бакалавр⁶, 3.6 мянга (15.5 %) нь магистр, 104 (0.5 %) нь докторын зэрэг эзэмшсэн байна. Нийт төгсөгчид 2010/2011 оны хичээлийн жилээс бакалаврынх 13.2 мянга (40.6 %)-аар бүүрч, магистрынх 411 (13.0 %)-аар, докторынх 10 (10.6 %)-аар тус тус өссөн байна.


Хүснэгт 6. Нийт төгсөгчид, боловсролын зэргээр, 2010-2019 он

| Үзүүлэлт | 2010/2011 | 2011/2012 | 2012/2013 | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2016/2017 | 2017/2018 | 2018/2019 |
|----------------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|---------------|
| Бүх төгсөгчид | 35 847 | 37 749 | 37 243 | 33 850 | 35 181 | 35 889 | 34 681 | 29 164 | 23 038 |
| Үүнээс: Эмэгтэй | 22 888 | 24 339 | 23 949 | 21 662 | 21 857 | 21 848 | 21 179 | 17 476 | 13 513 |
| Дипломын дээд | 1 387 | 918 | 1 181 | 259 | 93 | 231 | 495 | 45 | 409 |
| Үүнээс: Эмэгтэй | 1 048 | 655 | 910 | 121 | 25 | 128 | 364 | 17 | 68 |
| Бакалавр | 31 203 | 33 106 | 32 234 | 29 477 | 29 728 | 30 663 | 30 301 | 25 120 | 18 951 |
| Үүнээс: Эмэгтэй | 19 623 | 21 211 | 20 521 | 18 799 | 18 410 | 18 529 | 18 379 | 14 932 | 11 195 |
| Магистр | 3 163 | 3 626 | 3 697 | 3 996 | 5 254 | 4 859 | 3 772 | 3 868 | 3 574 |
| Үүнээс: Эмэгтэй | 2 161 | 2 412 | 2 434 | 2 676 | 3 358 | 3 104 | 2 374 | 2 446 | 2 185 |
| Доктор | 94 | 99 | 131 | 118 | 106 | 136 | 113 | 131 | 104 |
| Үүнээс: Эмэгтэй | 56 | 61 | 84 | 66 | 64 | 87 | 62 | 81 | 65 |

Нийт төгсөгчдийг мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд 5.1 мянга (22.2 %) нь худалдаа, бизнесийн удирдлагын чиглэлээр, 3.2 мянга (14.0 %) нь багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх чиглэлээр, 3.1 мянга (13.5 %) нь анагаах ухааны чиглэлээр, 3.0 мянга (13.1 %) нь инженерийн чиглэлээр, 1.7 мянга (7.2 %) нь хууль, эрх зүйн чиглэлээр, 6.9 мянга (30.0 %) нь бусад чиглэлээр тус тус төгссөн байна.


⁶ Бакалаврын зэргээр төгсөгчдөд дипломын дээд боловсролын зэргээр төгсөгчдийг оруулсан.

Зураг 57. Нийт төгсөгчид, дүнд эзлэх хувиар, мэргэжлийн тэргүүлэх чиглэлээр, 2010-2019 он




Төгсөгчдийн тоог салбараар авч үзвэл, 2018/2019 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 7.6 мянга (32.9 %) нь, 2010/2011 оны хичээлийн жилд 14.5 мянга (40.6 %) нь нийгмийн ухааны салбарын мэргэжлийнх байна.

Зураг 58. Нийт төгсөгчид, мянган хүн, мэргэжлийн ерөнхий чиглэлээр



2010/2011 оны хичээлийн жилд техник, технологийн салбарт 4.2 мянган оюутан төгссөний 60.2 хувь нь, 2018/2019 оны хичээлийн жилд 4.2 мянган оюутан төгссөний 73.0 хувь нь эрэгтэй байна. Харин анагаах ухааны салбарт 2010/2011 оны хичээлийн жилд 3.1 мянган оюутан төгссөний 83.4 хувь нь, 2018/2019 оны хичээлийн жилд 3.1 мянган оюутан төгссөний 83.6 хувь нь эмэгтэй байна.


Зураг 59. Нийт төгсөгчид, хүйсээр, мэргэжлийн ерөнхий чиглэлээр



1.6.5. Ажиллагчид



Их, дээд сургууль, коллежийн ажиллагчдын тоо 2010/2011 оны хичээлийн жилд 12.8 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 11.3 мянга болж, 1.3 мянга (10.2 %) -аар буурсан байна.

Зураг 60. Их, дээд сургууль, коллежийн ажиллагчид, өмчийн хэлбэрээр, 2010-2019 он




Их, дээд сургууль, коллежийн үндсэн багшийн тоо 2010/2011 оны хичээлийн жилд 7.2 мянга байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 7.3 мянга болж, 147 (2.0 %) -гоор өссөн байна. Үндсэн багшийн тоог хүйсээр авч үзвэл, 2010/2011 оны хичээлийн жилд нийт багшийн 4.2 мянга (58.1 %) нь, 2019/2020 оны хичээлийн жилд 4.5 мянга (61.3 %) нь эмэгтэй байна.

Зураг 61. Их, дээд сургууль, коллежийн үндсэн багш, хүйсээр, дүнд эзлэх хувиар, 2010-2019 он



2010/2011 оны хичээлийн жилд нэг багшид 24 оюутан ногдож байсан бол 2019/2020 оны хичээлийн жилд 16.7 хувиар буурч, нэг багшид 20 оюутан ногдож байна.

Зураг 62. Нэг багшид ногдох суралцагчид, 2010-2019 он



Нэг багшид ногдох оюутны тоог аймгаар авч үзвэл, Улаанбаатар хот болон Дархан-Уул, Орхон, Ховд, Архангай, Дорнод, Дорноговь аймгуудад 2019/2020 оны хичээлийн жилд нэг багшид 14.9-40.0 оюутан ногдож байгаа бол Баянхонгор, Хөвсгөл, Завхан, Говь-Алтай, Увс, Баян-Өлгий аймгуудад нэг багшид 10 хүрэхгүй оюутан ногдож байна.


Зураг 63. Нэг багшид ногдох суралцагчид, аймгаар, 2019/2020 оны хичээлийн жилд



1.6.6. Гадаадын их, дээд сургуульд суралцагчид

Засгийн газар хоорондын хэлэлцээр, төрийн сангийн зээлээр 2019 онд гадаадын их, дээд сургуульд нийт 1.5 мянган оюутан элссэний 91.5 хувь нь ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу, 8.5 хувь нь Боловсролын зээлийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцаж байна.

Зураг 64. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, төрийн сангийн зээлээр гадаадын их, дээд сургуульд суралцагчид, 2012-2019 он



Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2019 онд суралцаж буй 1359 суралцагчдыг суралцаж буй улсаар нь харуулбал, ОХУ-д 36.8 хувь нь, БНХАУ-д 25.9 хувь нь, Унгар улсад 14.7 хувь нь, Турк улсад 5.5 хувь нь, Япон улсад 4.3 хувь нь, суралцаж байгаа бол Энэтхэг, Польш, Вьетнам, Украин улсад 1.1-2.9 хувь нь суралцаж байна.

Хүснэгт 7. ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцагчид, суралцаж буй улсаар, 2012-2018 он


| Улс | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|-------------|------------|------------|------------|------------|--------------|--------------|--------------|--------------|
| ОХУ | 208 | 220 | 226 | 350 | 474 | 496 | 510 | 500 |
| БНХАУ | 319 | 355 | 353 | 376 | 361 | 399 | 358 | 352 |
| Унгар | 4 | 5 | 15 | 79 | 98 | 185 | 200 | 200 |
| Түрк | 53 | - | 35 | - | 75 | 75 | 75 | 75 |
| Япон | 58 | 58 | 35 | - | 58 | 58 | 58 | 58 |
| Энэтхэг | 50 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 | 40 |
| Польш | 21 | 23 | 22 | 23 | 23 | 25 | 25 | 25 |
| Вьетнам | 8 | 15 | 12 | 15 | 15 | 12 | 18 | 15 |
| Украин | 22 | 20 | 10 | 8 | 9 | 9 | 16 | 25 |
| Бусад | 23 | 22 | 28 | 33 | 51 | 78 | 76 | 69 |
| Бүгд | 766 | 758 | 776 | 924 | 1 204 | 1 377 | 1 376 | 1 359 |

1.7. БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТӨСӨВ, САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвөөс боловсролын салбарт 2010 онд 522.0 тэрбум төгрөгийг зарцуулж байсан бол 2019 онд 1.7 их наяд төгрөгт хүрч, 3.3 дахин нэмэгдсэн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагын дүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувийг авч үзвэл, 2010 онд 16.9 хувь байсан бол 2019 онд 15.3 хувь болж, 1.6 пунктээр, харин дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын салбарын зардлын эзлэх хувь 2010 онд 5.4 хувь байсан бол 2019 онд 4.7 хувь болж, 0.7 пунктээр тус тус буурсан байна.

Зураг 65. Улсын нэгдсэн төсвийн зарлага болон ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь, 2010-2019 он




1.8. ШИНЖЛЭХ УХААН, ОЮУНЫ ӨМЧИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

1.8.1. Шинжлэх ухааны салбарын үндсэн үзүүлэлт

Шинжлэх ухааны 62 байгууллага 2019 онд үйл ажиллагаа явуулсан байна. Шинжлэх ухааны салбарын нийт зардал 2019 онд 39.4 тэрбум төгрөг байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.1 хувийг эзэлж, 2010 оноос 0.1 пунктээр буурсан байна.

Зураг 66. ДНБ-д шинжлэх ухааны салбарын зардлын эзлэх хувь, 2010-2019 он



Шинжлэх ухааны 62 байгууллагад нийт 3.4 мянган үндсэн ажиллагчид байгаагийн 50.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 8. Эрдмийн зэрэг, цолтой үндсэн ажиллагчид, 2010-2018 он

| Үзүүлэлт | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|-----------------------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Бүгд | 2 517 | 2 583 | 2 672 | 2 694 | 2 724 | 2 515 | 2 211 | 3 482 | 3 246 | 3 352 |
| Эмэгтэй | 1 312 | 1 368 | 1 409 | 1 388 | 1 411 | 1 277 | 1 132 | 1 932 | 1 565 | 1 700 |
| Шинжлэх ухааны доктор | 114 | 127 | 124 | 143 | 135 | 95 | 77 | 130 | 109 | 136 |
| Боловсролын доктор | 428 | 478 | 487 | 486 | 496 | 495 | 432 | 797 | 706 | 657 |
| Академич | 36 | 50 | 48 | 48 | 46 | 38 | 32 | 46 | 56 | 38 |
| Профессор | 139 | 167 | 157 | 176 | 166 | 125 | 77 | 221 | 157 | 136 |
| Дэд профессор | 106 | 116 | 117 | 116 | 106 | 98 | 74 | 239 | 187 | 166 |

Улсын төсвөөс 2019 онд нийт 309 эрдэм шинжилгээний ажлыг санхүүжүүлсний 30.4 хувийг шинжлэх ухаан, технологийн төсөл эзэлж байна.

Хүснэгт 9. Улсын төсвөөс санхүүжүүлсэн эрдэм шинжилгээний ажил, 2010-2019 он

| Судалгааны ажлын төрөл | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---------------------------------------|------|------|------|------|------|------|------|------|------|------|
| Бүгд | 466 | 454 | 453 | 506 | 429 | 366 | 319 | 276 | 320 | 309 |
| Шинжлэх ухаан, технологийн төсөл | 237 | 270 | 271 | 333 | 271 | 206 | 160 | 94 | 131 | 94 |
| Онолын суурь судалгаа | 191 | 148 | 145 | 141 | 135 | 160 | 159 | 169 | 189 | 215 |
| Шинжлэх ухаан, технологийн зэхэц ажил | 38 | 36 | 37 | 32 | 23 | - | - | 13 | - | - |

1.8.2. Оюуны өмчийн салбарын үндсэн үзүүлэлт

Оюуны өмчийн газрын мэдээллээр улсын хэмжээнд 2019 онд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 407 бүтээлд шинээр патент олгосны 192 нь шинэ бүтээлийнх, 215 нь бүтээгдэхүүний загварынх байна. Нийт олгосон патент 2019 онд өмнөх оноос 60 (17.3%)-аар нэмэгдсэн байна. Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар хүчинтэй 4417 патент байгаагаас 1138 нь шинэ бүтээлийн патент, 3279 нь бүтээгдэхүүний загварын патент байна.

Хүснэгт 10. Патент, 2016-2019 он

| Үзүүлэлт | Шинэ бүтээл | | | | Бүтээгдэхүүний загвар | | | |
|----------------------------------|-------------|------------|------------|--------------|-----------------------|------------|--------------|--------------|
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
| Нийт патентын мэдүүлэг | 221 | 230 | 159 | 170 | 274 | 299 | 269 | 300 |
| Дотоодын мэдүүлэг | 111 | 115 | 82 | 85 | 125 | 163 | 140 | 180 |
| Иргэн | 75 | 80 | 54 | 54 | 67 | 77 | 65 | 88 |
| Хуулийн этгээд | 36 | 35 | 28 | 31 | 58 | 86 | 75 | 92 |
| Гадаадын мэдүүлэг | 10 | 20 | 10 | 6 | 9 | 9 | 38 | 3 |
| Иргэн | - | - | 1 | 1 | - | - | - | 1 |
| Хуулийн этгээд | 10 | 20 | 9 | 5 | 9 | 9 | 38 | 2 |
| Олон улсын мэдүүлэг ¹ | 100 | 95 | 67 | 79 | 140 | 127 | 91 | 117 |
| Иргэн | 14 | 6 | 5 | 5 | - | - | - | 4 |
| Хуулийн этгээд | 86 | 89 | 62 | 74 | 140 | 127 | 91 | 113 |
| Нийт олгосон патент | 158 | 104 | 76 | 192 | 275 | 228 | 271 | 215 |
| Хүчинтэй байгаа патент | - | - | 997 | 1 138 | - | - | 3 742 | 3 279 |

Тайлбар: ¹ Шинэ бүтээлийн патент авахаар Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу болон бүтээгдэхүүний загварын патент авахаар Гаагийн хэлэлцээрийн дагуу тус тус мэдүүлсэн Монгол Улсыг нэр зааж гаргасан Олон улсын мэдүүлэг.

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар хүчинтэй 995 ашигтай загвар байна. Иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 166 ашигтай загварт гэрчилгээ олгосон нь өмнөх оноос 14 (9.2 %)-өөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 11. Ашигтай загвар, 2016-2019 он

| Үзүүлэлт | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|------------|------------|------------|------------|
| Нийт ашигтай загварын мэдүүлэг | 204 | 257 | 223 | 229 |
| Дотоодын мэдүүлэг | 202 | 257 | 223 | 226 |
| Иргэн | 167 | 213 | 176 | 179 |
| Хуулийн этгээд | 35 | 44 | 47 | 47 |
| Гадаадын мэдүүлэг | 2 | - | - | 3 |
| Иргэн | - | - | - | 1 |
| Хуулийн этгээд | 2 | - | - | 2 |
| Гэрчилгээ олгосон ашигтай загвар | 137 | 164 | 152 | 166 |
| Хүчинтэй байгаа ашигтай загвар | - | - | 916 | 995 |

Бүтээлээ зохиогчийн эрхээр хамгаалуулахаар 2019 онд 1007 иргэн мэдүүлэг гаргаснаас бүх бүтээлд шинээр зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосон байна.

Хүснэгт 12. Зохиогчийн эрх, төрлөөр, 2016-2019 он

| Төрөл | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|--|--------------|------------|--------------|--------------|
| Нийт зохиогчийн эрхийн мэдүүлэг | 1 025 | 674 | 1 072 | 1 007 |
| Шинжлэх ухаан, утга зохиолын бичмэл буюу аман төрөлд хамаарах бүтээл, түүнчлэн компьютерын программ | - | 597 | 938 | 748 |
| Хөгжмийн урлагийн үгтэй болон үггүй бүтээл | - | 19 | 40 | 6 |
| Дүрслэх урлагийн төрөлд хамаарах бүтээл | - | 14 | 21 | 65 |
| Чимэглэх болон хавсарга урлаг, тайз чимэглэлийн төрөлд хамаарах бүтээл | - | - | 2 | 1 |
| Архитектурын бүтээл, уран баримал, уран барилгын төрөлд хамаарах бүтээл | - | 8 | 15 | 14 |
| Бүжгийн урлагийн бүтээл | - | - | - | 13 |
| Жүжиг, хөгжимт жүжиг, тайзны урлагийн төрөлд хамаарах бүтээл | - | - | - | 1 |
| Гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар түүрвисан бүтээл | - | - | 1 | 3 |
| Дуу авиа бүхий дүрст бүтээл /телевизийн нэвтрүүлэг, кино урлагийн бүтээл/ | - | 32 | 35 | 46 |
| Үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл | - | 2 | 18 | 39 |
| Материалыг нь сонгон түүвэрлэх, байршуулах зэргээр бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон, өөрийн бүтэц агуулгаараа оюуны бүтээлд тооцогдох тайлбар толь, лавлах, зохиолын цоморлог, өгөгдөхүүн-мэдээллийн сангийн бусад эмхэтгэлүүдийн төрөлд хамаарах бүтээл | - | 2 | 2 | 69 |
| Ардын урлагийн бүтээлд тулгуурлан түүрвисан үүсмэл бүтээлийн төрөлд хамаарах бүтээл | - | - | - | 2 |
| Бусад зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлэхүйц бүтээл | - | - | - | - |
| Зохиогчийн эрхээр хамгаалах бүтээлд олгосон гэрчилгээ | 1 025 | 674 | 1 072 | 1 007 |

Монгол Улсын хэмжээнд 2019 оны байдлаар хүчинтэй 48.0 мянган барааны тэмдэгт байна. Барааны тэмдгийн эрхийн хамгаалалт авахаар 2019 онд 4603 иргэн, хуулийн этгээд мэдүүлэг гаргасан байна. Нийт мэдүүлсэн барааны тэмдгийн 2403 нь Мадридын хэлэлцээрийн дагуу Монгол Улсыг нэр зааж гаргасан олон улсын мэдүүлэг байна.

Иргэн, хуулийн этгээдийн ирүүлсэн 3927 барааны тэмдэгт эрхийн хамгаалалт олгосон нь өмнөх оноос 422 (12.0 %)-оор нэмэгдсэн байна.

Монгол Улсын хэмжээнд 2019 онд газар зүйн 1 заалтад эрхийн хамгаалалт олгосон байна.


Хүснэгт 13. Барааны тэмдэг болон газарзүйн заалт, 2016-2019 он

| Үзүүлэлт | Барааны тэмдэг | | | | Газар зүйн заалт | | | |
|---|----------------|--------------|---------------|---------------|------------------|----------|----------|----------|
| | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
| Нийт барааны тэмдэг болон газар зүйн заалтын мэдүүлэг | 3 400 | 3 803 | 4 374 | 4 603 | 1 | 2 | 1 | - |
| Дотоодын мэдүүлэг | 1 140 | 1 351 | 1 431 | 1 581 | 1 | 1 | - | - |
| Иргэн | 304 | 332 | 354 | 480 | - | - | - | - |
| Хуулийн этгээд | 836 | 1 019 | 1 077 | 1 101 | 1 | 1 | - | - |
| Гадаадын мэдүүлэг | 557 | 468 | 576 | 619 | - | 1 | 1 | - |
| Иргэн | 16 | 8 | 5 | 20 | - | - | - | - |
| Хуулийн этгээд | 541 | 460 | 571 | 599 | - | 1 | 1 | - |
| Олон улсын мэдүүлэг ¹ | 1 703 | 1 984 | 2 367 | 2 403 | - | - | - | - |
| Иргэн | 10 | 19 | 10 | 58 | - | - | - | - |
| Хуулийн этгээд | 1 693 | 1 965 | 2 357 | 2 345 | - | - | - | - |
| Нийт эрхийн хамгаалалт олгосон барааны тэмдэг болон газар зүйн заалт | 2 605 | 3 318 | 3 505 | 3 927 | 3 | 2 | - | 1 |
| Хүчинтэй байгаа барааны тэмдэг | - | - | 45 696 | 47 983 | - | - | - | - |

1.9. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ЗАРИМ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ОЛОН УЛСЫН ХАРЬЦУУЛАЛТ

Бусад улс орнуудын СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоог харьцуулан дараах зурагт харуулав. СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоогоор хамгийн бага нь Швед улс (5.5), ХБНГУ (7.7), Финланд улс (11.1) байгаа бол хамгийн их нь Мексик улс (25.0), Бразил улс (16.5) байна. Харин Монгол Улсын хувьд СӨБ-ын нэг багшид 33.3 хүүхэд ногдож байна.


Зураг 67. СӨБ-ын байгууллагын нэг багшид ногдох хүүхэд, улсаар, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Монгол Улсын бага боловсролын багш нарын 96.1 хувь нь эмэгтэй багш байна. Энэ үзүүлэлтийг зарим улс орнуудаар харьцуулан дараах зурагт харуулав. Тухайлбал, ОХУ-д нийт багшийн 95.6 хувь нь, Индонез улсад 66.0 хувь нь эмэгтэй багш байна.


Зураг 68. Бага боловсролын нийт багшид эмэгтэй багшийн эзлэх хувь, улсаар, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Суурь боловсрол төгсөгчдийн бохир жинг авч үзвэл, Норвеги улсад 101.7 хувь нь, Финланд улсад 98.0 хувь нь, ОХУ-д 94.8 хувь нь, Монгол Улсад 82.5 хувь нь, Бразил улсад 76.4 хувь нь, Бельги улсад 76.0 хувь байна.


Зураг 69. Суурь боловсрол төгсөгчдийн бохир жин, улсаар, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Их Британи Улсын дээд боловсролын нийт суралцагчдын 17.9 хувь нь, Австри Улсын 17.2 хувь нь, Нидерланд Улсын 11.0 хувь нь гадаад оюутан байгаа бол Монгол Улсын нийт суралцагчдын 1.0 хувь нь, Мексик, Бразил, Колумби, Индонез Улсуудад 1 хүрэхгүй хувийг гадаад оюутнууд эзэлж байна.


Зураг 70. Дээд боловсролд суралцаж буй гадаад оюутан, дүнд эзлэх хувиар, улсаар, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

Дээд боловсролд суралцах хугацааг 2017 оны байдлаар авч үзвэл, Турк улс 5.7 жил, Финланд 4.3 жил байгаа нь хамгийн өндөр байна. Харин хамгийн бага нь Бразил улс 2.4 жил, Их Британи улс 2.9 жил байна. Монгол Улсын хувьд дээд боловсрол эзэмшихээр суралцаж байгаа хугацаа 3.1 жил байна.


Зураг 71. Дээд боловсролд суралцах хугацаа, жилээр, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

ДНБ-д шинжлэх ухааны салбарын зардлын эзлэх хувиар БНСУ (4.6 %), Израйл улс (4.5 %) хамгийн өндөр байна. Монгол Улсын хувьд маш бага буюу дөнгөж 0.1 хувийг эзэлж байна.

Зураг 72. ДНБ-д дотоодын шинжлэх ухааны салбарын зардлын эзлэх хувь⁷, 2017 он



Эх үүсвэр: ЮНЕСКО-гийн Статистикийн институт

⁷ <http://uis.unesco.org/en/news/rd-data-release-explore-human-and-financial-resources-invested-science>

БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ

- ✓ Монгол Улсын эдийн засаг 2019 онд 5.1 хувиар өсөж, дотоодын нийт бүтээгдэхүүн 36.9 их наяд төгрөгт хүрсэн байна. ДНБ-д боловсролын салбарын зардлын эзлэх хувь 4.7 хувь, шинжлэх ухааны салбарын эзлэх хувь 0.1 хувь байна. Энэ нь цаашид дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх боловсрол, шинжлэх ухааны салбарын нийт зардлын хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.
- ✓ Цэцэрлэгийн тоо тогтмол нэмэгдэж байгаа хэдий ч цэцэрлэгийн бүлэг дүүргэлт өндөр, цэцэрлэгт хамрагдвал зохих 2-5 насны хүүхдийн хамрагдалт бага хэвээр байна.
Цэцэрлэгийн нэг бүлэгт ногдох хүүхдийн тоог бүлгээр харуулбал, хамгийн олон хүүхэдтэй нь бэлтгэл бүлэг (36), ахлах бүлэг (35), дунд бүлэг (33), бага бүлэг (27) байгаа бол хамгийн цөөхөн хүүхэдтэй нь холимог бүлэг (22) байна. Энэ үзүүлэлт нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/118 тушаалаар батлагдсан “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.6-д бага бүлгийг дунджаар 20 хүүхэд, дунд, ахлах, бэлтгэл бүлгийг дунджаар 25 хүүхэд, холимог бүлгийг дунджаар 20 хүүхэдтэй байхаар тогтоосон стандартаас давсан байна.
- ✓ 2019/2020 оны хичээлийн жилд ЕБС-ийн бага ангийн бүлэг дүүргэлт хөдөө орон нутагт стандарт хэмжээнд, харин нийслэлийн зарим дүүрэгт (Сонгинохайрхан, Чингэлтэй, Баянгол, Багануур, Баянзүрх) Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 307/91/237 тушаалын хавсралтад анги дүүргэлтийг бага ангид 30-35 хүүхэдтэй байхаар тогтоосон стандартаас давсан байна.
- ✓ 2018/2019 онд суурь боловсролыг 41913 сурагч өдрөөр суралцан төгссөний 20.0 хувь нь 2019/2020 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинээр элссэн байна. Харин 2018/2019 оны хичээлийн жилд бүрэн дунд боловсролыг 16440 сурагч өдрөөр суралцан төгссөний 17.1 хувь нь 2019/2020 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад элссэн байна. Иймд суурь болон бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс техникийн болон мэргэжлийн боловсролд суралцагчдын тоог тогтмол нэмэгдүүлэх нь хүн амын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйчүүд, ядуурлыг бууруулахад эергээр нөлөөлөх юм.
- ✓ 2019/2020 оны хичээлийн жилд мэргэжлийн боловсролд суралцаж буй 100 эрэгтэй суралцагч тутамд 70 эмэгтэй ногдож байгаа бол дээд боловсролд суралцаж буй 100 эрэгтэй оюутан тутамд 157 эмэгтэй ногдож байгаа нь жендэрийн тэнцвэрт байдал алдагдаж буйг харуулж байна.
- ✓ 2018/2019 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийг нийт төгсөгчдийн 8.0 мянга (34.6%) нь ажлын байртай болсон байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн чиглэл, сургалтын орчныг шинэчлэн зохион байгуулах, багш нарын мэргэжлийн үр чадвар, суралцагчдын сургалтын чанарыг эрс дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, зохицуулалтын арга хэмжээг дэс дараалан авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ХАВСРАЛТ

1. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

1.1. Боловсролын тухай ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын “Боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадвартай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино” гэж заасан.

Монгол Улсын “Боловсролын тухай” хуульд заасны дагуу манай улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ.

Хүний түвшинд боловсрол гэдэгт хүний өөрийгөө боловсруулж хөгжүүлэхийн тулд ухамсартайгаар хийж байгаа танин мэдэхүйн үйл ажиллагаа, түүний үр дүнг ойлгоно.

Нийгмийн түвшинд боловсрол гэдэгт иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь төр, нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлж байгаа үйлчилгээ, түүний үр дүнг ойлгоно.

Сургалтын байгууллага гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг ойлгоно гэж тодорхойлсон.

Боловсролын түвшин: Тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээ юм.

Албан боловсрол: Боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа юм.

Албан бус боловсрол: Боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа юм.

Насан туршийн боловсрол: Бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг ойлгоно.

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

“Бүх нийтийн ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг, “суурь боловсрол” гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг ойлгодог. Бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь ерөнхий боловсролын сургууль юм.

Мэргэжил гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг хэлнэ /Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Мэргэжлийн боловсрол гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ гэж тодорхойлжээ /Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль/.

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна.

Бичиг үсэг мэддэг гэж аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн энгийн богино өгүүлбэрүүдийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг ойлгоно.

Бичиг үсэг мэддэггүй гэж аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших, бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг хэлнэ.

Мөн уншдаг боловч бичиж чаддаггүй, өөрөөр хэлбэл унших, ойлгох, бичих чадварын аль нэгийг эзэмшээгүй тохиолдолд бичиг үсэг мэддэггүй гэж ойлгоно.

Бичиг үсэг мэддэг 15, түүнээс дээш насны хүн амын тоог тухайн насны бүх хүн амын тоонд харьцуулж, бичиг үсэг тайлагдалтын хувийг тодорхойлно.

Хамран сургалтын бохир жинг тооцохдоо нас харгалзалгүйгээр боловсролын тухайн түвшинд суралцагчдын тоог энэ түвшний боловсрол эзэмших насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Хамран сургалтын цэвэр жинг тооцохдоо аль нэг боловсролын түвшний тухайн насны суралцагчдын тоог тухайн насны хүн амын тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Сурагч-багшийн тооны харьцааг боловсролын тухайн түвшний боловсролын байгууллагад суралцагчдын тоог энэ түвшний багшийн тоонд харьцуулж тодорхойлно.

Сургуульд суралцах хугацаа гэж тухайн насны суралцагчийн ирээдүйд суралцах жилийн нийлбэр болно. Тухайн суралцагчийн тодорхой насандаа сургуульд элсэн орох магадлал нь одоогийн хамран сургалтын жинтэй тэнцүү гэж үздэг.

Жендерийн тэнцвэрт байдлын индекс гэж тодорхой нэг үзүүлэлтийн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тоон харьцааг ойлгоно.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж тайлант хугацаанд улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулж байгаа үрсгал болон хөрөнгө оруулалтын зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг хэлнэ. Боловсролын салбарт зарцуулж байгаа нийт зардлыг тооцохдоо холбогдох бүх яам, бүх шатны засаг захиргааны байгууллага, агентлаг, бие даасан институтийг хамарна.

Улсын нэгдсэн төсвийн зарлагад боловсролын төсвийн зардлын эзлэх хувь гэж Улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулсан нийт зардлыг тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад харьцуулж, хувиар илэрхийлнэ.

Эмэгтэй багш нарын эзлэх хувь гэж нэг хичээлийн жилд тухайн боловсролын түвшинд ажиллаж байгаа эмэгтэй багш нарын нийт багшийн дүнд эзлэх хувь болно.

1.2. Шинжлэх ухаан, оюуны өмчийн тухай ойлголт, тодорхойлолт

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа: Эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг юм.

Технологи гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогц юм.

Инноваци гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг ойлгоно.

Шинжлэх ухаан, технологийн төсөл: Эрдэм шинжилгээ, түршилт, зохион бүтээх ажлыг онол, арга зүйн өндөр түвшинд явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүнд бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичиг юм.

Шинжлэх ухаан, технологийн зэхэц ажил: Эрдэм шинжилгээ, түршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон, цаашид инкубаторт бойжуулан худалдах буюу шууд жижиг, дүнд үйлдвэрлэл бий болгох боломжтой шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүний загвар, технологи, түршилтын тоног төхөөрөмж зэргийг хэлнэ.

Эрдэм шинжилгээний үндсэн ажилтан: Эрдэм шинжилгээний байгууллагад үндсэн орон тооны эрдэм шинжилгээ, түршилт, зохион бүтээх ажлыг дагнан хийдэг үндсэн ажилтныг хэлнэ.

Эрдмийн зэрэгтэй ажилтан: Дээд боловсролын хуулиар баталсан шаталсан сургалтын шалгуурыг хангаж боловсролын зэрэг хамгаалсан ажилтныг хэлнэ.

Оюуны өмч: Шинэ бүтээл, утга зохиолын болон уран сайхны бүтээл, худалдаанд хэрэглэдэг тэмдэг, нэр, дүрс зэрэг оюуны бүтээл хамаарна. Оюуны өмчийг хоёр хэсэгт ангилна. Үүнд:

- Аж үйлдвэрийн өмч: Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт хамаарна;
- Зохиогчийн эрх: Роман, тууж, шүлэг, яруу найраг, жүжгийн зохиол гэх мэт утга зохиолын бүтээл, кино, хөгжмийн бүтээл, уран зураг, гэрэл зураг гэх мэт уран сайхны бүтээл, уран баримал, архитектурын бүтээл хамаарна.

Патент: Тодорхой зүйлийг хийх шинэ арга замыг гаргасан эсвэл аливаа техникийн шинэ шийдлийг санал болгож буй бүтээгдэхүүн болон арга ажиллагаанд (шинэ бүтээл, ашигтай загварт) өгч буй онцгой эрх юм.

Шинэ бүтээл: Байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах, шинэ бүтээлийн түвшин агуулсан шинэ шийдлийг ойлгоно.

Бүтээгдэхүүний загвар: Аливаа эд зүйлийн чимэглэл буюу гоо зүйн гадаад хэлбэр үзэмж нь байдаг. Хийц загвар нь гадна хэлбэр, гадаргуу гэх мэт эзэлхүүнт илэрхийлэл эсвэл зураас, шугам, өнгө гэх мэт хавтгайн илэрхийлэл байж болно.

Зохиогчийн эрх: Зохиогчид өөрсдийн уран зохиолын болон урлагийн бүтээлүүдийн эзэмших эрхийг ашиглахад хэрэглэдэг хуулийн нэр томъёо юм. Зохиогчийн эрхийн бүтээлд ном, хөгжим, уран зураг, уран баримал, кино, компьютерийн програм, мэдээллийн сан, зар сурталчилгаа, газрын зураг, техникийн зураг зэрэг бүтээл багтдаг.

Ашигтай загвар: Үйлдвэрлэлийн багаж, хэрэгсэл, аргад хамаарах, үйлдвэрлэлд ашиглах боломжтой техникийн шинэ шийдлийг ойлгоно.

Барааны тэмдэгт: Иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийлэл юм.

Газар зүйн заалт: Газар зүйн онцлог гарал үүсэлтэй болохынхоо хувьд өвөрмөц чанар, өндөр нэр хүнд олж авсан бараанд хэрэглэгддэг нэг ёсондоо тэмдэг юм.

2. СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Боловсролын салбарын статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистикийн мэдээлэл байдаг. Түүнчлэн 10 жил тутам явагддаг ХАОСТ болон өрхөд суурилсан түүвэр судалгаанууд (АХС, ӨНЭЗС, НҮТС гэх мэт)-аас боловсролын статистикийн үзүүлэлтийг тооцон гаргаж байна. Боловсролын статистикийн захиргааны мэдээллийг тогтоосон хугацаанд цэцэрлэг, бүх шатны сургуулиас цуглуулдаг.

Мөн шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны захиргааны маягтын дагуу жилд нэг удаа, оюуны өмчийн статистикийн мэдээллийг Оюуны өмчийн газраас сар бүр албан ёсны маягтын дагуу цуглуулж байна.

3. СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН АШИГЛАЛТ

Боловсролын статистик нь хүний амьдралын чанарын болон улс орны хөгжлийн чухал үзүүлэлтүүдийг бүрдүүлдэг. НҮБ-ын Статистикийн хүрээлэнгээс 2009 онд хэвлэн гаргасан боловсролын үзүүлэлтүүдийн техникийн гарын авлагыг үндэслэн үндэсний боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлалыг 2013 онд батлан, уг аргачлалын дагуу үзүүлэлтүүдийг тооцон гаргаж байна.

Түүнчлэн олон улсын боловсролын стандарт ангилал (ISCED 2011)-д нийцүүлэн Монгол улсын боловсролын ангилал, кодыг 2013 онд баталж, тооллого, судалгаа болон боловсролын бусад мэдээлэлд ашиглаж байна.

Боловсрол, шинжлэх ухаан, оюуны өмчийн статистик мэдээллийг батлагдсан маягаар цуглуулж, жил, сар бүрийн бюллетень, танилцуулга, жилийн эмхэтгэлд тусган нийтийн хүртээл болгож байна.

Эдгээр статистикийн мэдээллийг Засгийн газрын мөрийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, салбарын нэмэгдэл өртгийн тооцоо хийх, хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцох, тогтвортой хөгжлийн зорилт, бүх нийтийн боловсрол (*Education for all*) хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг тооцоход ашиглаж байгаагаас гадна ЮНЕСКО-гоос жил бүр гаргадаг эмхэтгэлд боловсролын салбарын хүртээмжийн, дотоод үр ашгийн, үр дүнгийн, санхүүгийн болон хүний нөөцийн үзүүлэлтийг ЮНЕСКО-гоос боловсруулсан аргачлалын дагуу тооцон оруулж байна.